

Тендерийн дугаар: ЭКМ/20260602129
Тендерийн нэр:Арчих материал

“Техникийн тодорхойлолт”

Мэдээлэл: Арчих материал нь үйлдвэрлэлийн аль ч салбарын аж ахуйн нэгжүүдэд ашиглах зориулалттай, аюулгүй байдлын шаардлагыг хангасан, ариутгагдсан, цэвэр, 100% даавуун төрлийн материал байна. Арчих материалыг янз бүрийн гадаргууг арчих, асгарсан шингэн, тос, түлш, зузаан наалдамхай бодис, нунтагласан эд ангиудыг арилгах, металл бэлдэц боловсруулалтын цэвэрлэгээ зэрэг ажилд хэрэглэнэ.

Тавигдах шаардлага:

- Даавуу материал нь ихэвчлэн байгалийн гаралтай түүхий эдээс бүрдсэн даавуу байх, нийлэг, ноосон болон синтетик материалаар хийгдээгүй байх
- Даавуу материал нь сайн шингээх чадварыг агуулсан байх
- Даавуу материал нь зөвхөн энгийн тос, наалдамхай бодис, төрөл бүрийн шингэнийг шингээн авах нөхцөл хангасан байх
- Даавуу материал нь металл эд анги, механизмын гадаргууг арчиж зүлгэхэд бат бөх төдийгүй уян хатан чанартай байх
- Даавуу материал нь металл эд анги, механизмын гадаргууг арчиж зүлгэхэд материалаас хөвөн болон бусад төрлийн биет үлдээхгүй, гадаргууг зурж гэмтээхгүй байх
- Даавуу материал нь дан нэг төрлийн байж болно, хэмжээг тухайлан заахгүй
- Даавуу материалын савалгаа нь нэг боодолдоо 60 кг -аас багагүй байна.
- Нийлүүлэх хуваарь

№	Нийлүүлэх материал	Хугацаа	Нийлүүлэх хэмжээ
1	Арчих материал	2026.02.15	13 боодол
2	Арчих материал	2026.04.15	12 боодол